



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 8/МЗ

Батноров сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам"-ын 11.10 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай" 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын 2024 оны А/83 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад ялагч болсон 6 (зургаа) малчдын хоршоонд хавсралтад заасан газрыг эзэмшүүлсүгэй.

2.Малчдын хоршоонд эзэмшүүлсэн нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж, газар эзэмших эрхийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээг баталгаажуулыг Газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Газрыг зориулалтын дагуу ашиглаж, гэрээнд заасан нөхцөл, болзлын хүрээнд газрын төлбөрийг хугацаанд төлөхийг газар эзэмшигч малчдын хоршоо тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЖАВХЛАНБАЯР

230423330

Батноров сумын Засаг даргын
2024 оны дугаар сарын 22-ны өдрийн
А/..... дугаар захирамжийн хавсралт



ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА

№	Газар эзэмшигчийн нэр (хоршоо)	Регистрийн н дугаар	Төлөвлөлтийн н нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Хэмжээ (га)	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	Шинэ хөдөөгийн эхлэл хоршоо	4208625	4120460	Эрдэнэмандмань Бэрхийн хөндий	5	Мал аж ахуйн үйлдвэрлэл	40 жил
2	Овжин малчид хоршоо	4211936	4117766	Идэрмэг, Олон нуур	5	Мал аж ахуйн үйлдвэрлэл	40 жил
3	Буурал зос хоршоо	4212096	4117765	Эрдэнэмандмань , Нуурын толгой	5	Мал аж ахуйн үйлдвэрлэл	40 жил
4	Ундралангуй агро хоршоо	4212282	4117769	Баян булаг баг Төмстийн ар	5	Малын тэжээлийн ургамал тариалах	40 жил
5	Хөхүүрийн талын шим агро хоршоо	4212568	4117768	Баян булаг баг Төмстийн ар	5	Малын тэжээлийн ургамал тариалах	40 жил
6	Их хөхүүрт агро хоршоо	4212312	4117767	Баян булаг баг Төмстийн ар	5	Малын тэжээлийн ургамал тариалах	40 жил
Дүн					30		